



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Эх оронч цэрэг-2028”
арга хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, улс орны хөгжилд иргэн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгуулж, эх орноороо болон монгол хүн болж төрснөөрөө бахархах бахархлыг тээгч байх, улс орныхоо тусгаар тогтнолын баталгааг нэмэгдүүлэх зорилго бүхий “Эх оронч цэрэг-2028” арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2.Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

D/2025-togtool

1150100024

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны
өдрийн 01 дугаар тогтоолын хавсралт

“ЭХ ОРОНЧ ЦЭРЭГ-2028” АРГА ХЭМЖЭЭ

Нэг.Нийтлэг үндэслэл

Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэх, өөрийгөө таних, эх орноо хайрлан хамгаалах, хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүргийг ухааруулан ойлгуулж, эх орон, тусгаар тогтнол, эх хэл, үндэсний түүх соёлоороо бахархах, дээдлэн хүндэтгэх, газар нутаг, байгаль орчноо хайрлах итгэл үнэмшлийг төрүүлэх үндсэн зорилгыг дэвшүүлж байна.

Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, монгол хүний хөгжил, эх оронч ухамсар, хандлагыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, чанарыг дээшлүүлэх болно.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.3.7-д “Эх орны дуудлага-эр цэргийн алба” зорилтын хүрээнд батлан хамгаалах үйл хэргийг иргэдэд сурталчилж, хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлж, цэргийн сургалтын тогтолцоонд шинэчлэл хийж, цэргийн албаны төрлийг нэмэгдүүлэх замаар Зэвсэгт хүчин, алба хаагчийн олон нийтийн дэмжлэг, нэр хүндийг дээшлүүлнэ.” гэх зорилт тусгагдсан нь энэ арга хэмжээг боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр.Арга хэмжээний зорилго

Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, улс орны хөгжилд иргэн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгуулж, эх орноороо болон монгол хүн болж төрснөөрөө бахархах бахархлыг тээгч байх, улс орныхоо тусгаар тогтнолын баталгааг нэмэгдүүлэхэд энэ арга хэмжээний зорилго оршино.

Гурав.Арга хэмжээний зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

Зорилт 1.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.

Зорилт 1-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1.1.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.

1.2.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэхэд бүх талын оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулна.

1.3.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, ёс зүй, ухамсрыг төлөвшүүлэх, Улс, үндэстний тусгаар тогтнолын үнэ цэнийг сурталчлан дэлгэрүүлнэ.

Хүрэх үр дүн:

-Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Эх оронч үзэл төлөвшүүлэх” үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

-Хүүхэд, залуучуудын нийгмийн идэвх оролцоо сайжирч, тусгаар тогтнолын үнэ цэнэ, Монгол Улсын Батлан хамгаалах үйл ажиллагааг ойлгох суурь тавигдана.

Зорилт 2. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэхэд бүх талын оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулна.

Зорилт 2-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

2.1.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлнэ.

2.2.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэхэд бүх шатны байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа харилцан уялдана.

2.3.Монгол хүн бие биенээ хүндэтгэх, харилцан туслах, байгаль орчноо хайрлан хамгаалах нийгмийн орчин сайжирна.

Хүрэх үр дүн:

-Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэхэд бүх шатны байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа харилцан уялдааг хангасан байна.

-Хүүхэд, залуучуудын ахмад үеэ хүндлэх, байгаль орчноо хайрлах үзлийг нэмэгдүүлж, нийгэмд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлсэн байна.

Зорилт 3.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, ёс зүй, ухамсрыг төлөвшүүлэх, улс, үндэстний тусгаар тогтнолын үнэ цэнийг сурталчлан дэлгэрүүлнэ.

Зорилт 3-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

3.1.Эх орон, тусгаар тогтнолоороо бахархах, хайрлан хамгаалах, хөгжүүлэх үйл хэрэгт хүүхэд, залуучуудын оролцоо нэмэгдэж, тэдний оюун санаа, ухамсарт эерэг хандлага төлөвшиж, бие бялдрын хөгжил сайжирна.

3.2.Гэр бүлийн орчинд эх оронч үзэл, зөв хүмүүжил олгох олон талт арга хэмжээг зохион байгуулна.

Хүрэх үр дүн:

-Гэр бүлийн орчинд эх орон, тусгаар тогтнолын үнэ цэнийг ойлгуулах үйл ажиллагаа тогтмолжино.

-Ахлах ангийн сурагчдын эх оронч үзэл хүмүүжлийг бэхжүүлж, тэдний хойч үеэ эх орон, тусгаар тогтнолоороо бахархах, хайрлан хамгаалах үйл хэргийг үлгэрлэн дуурайлгах боломж бүрдсэн байна.

Дөрөв.Арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

4.1.Арга хэмжээг 2024-2028 онд хэрэгжүүлнэ.

4.2.Арга хэмжээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

4.2.1. Улсын болон орон нутгийн төсөв;

Тав.Арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт

5.1.Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага:

-Засаг даргын Тамгын газар (Цэргийн штаб, Нийгмийн хөгжлийн хэлтэс)

-Боловсролын хэлтэс

-Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс

-Дүүргийн 1-24 дүгээр хороод

5.2.Хяналт тавих байгууллага:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Зургаа.Арга хэмжээний хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1.Арга хэмжээний хэрэгжилтэд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх бөгөөд Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб хэрэгжилтийн тайланг дараа оны I улиралд багтаан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

6.2.Шаардлагатай тохиолдолд арга хэмжээ хэрэгжиж эхэлснээс хойш 18 сараас доошгүй хугацааны дараа үр дүнд суурилсан явцын болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэж болно.

6.3.Арга хэмжээг хэрэгжүүлэх үе шат

6.3.1.I үе шат (2025-2026 он): Хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх тогтолцоог бүрдүүлнэ;

6.3.2.II үе шат (2027-2028 он): Эхний шатны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, эх оронч үзлийг төлөвшүүлэх тогтолцоог бэхжүүлнэ.

Долоо.Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт

7.1.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.1.1.Нутаг дэвсгэрийн онцлогт тулгуурласан эх оронч үзлийг хүүхэд, залуучуудад төлөвшүүлж, хөгжүүлэх;

7.1.2.Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг бүх шатны байгууллага, аж ахуйн нэгжид хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үйл ажиллагааг уялдуулах, хамтран хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх;

7.1.3.Эх оронч үзлийн чиглэлээр дагнасан судалгаа, шинжилгээ явуулдаг байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллах;

7.1.4.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, соён гэгээрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд боловсролын байгууллагуудаас гадна төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, эцэг, эх, иргэдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх;

7.2.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэхэд бүх талын оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.2.1.Эцэг, эх, гэр бүлийн зүгээс үр хүүхдэдээ эх оронч үзэл төлөвшүүлэх үүрэг, зорилгын хүрээнд баримтлах арга зүйн зөвлөмж боловсруулж, сурталчлан таниулах;

7.2.2.Ахмад үеэ хүндэтгэх, үлгэрлэн дуурайх, тэдний улс орныхоо төлөө байгуулсан гавьяа, хөдөлмөр, зүтгэлийг сурталчлан, хувь хүн бүрийн оролцоо улс орны хөгжилд ямар чухал болохыг ойлгуулж, төрөлх эх орон, монгол хүн болж төрснөөрөө бахархах сэтгэлгээ, төлөвшлийг олгох ажлыг жил бүр зохион байгуулах;

7.3.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, ёс зүй, ухамсрыг төлөвшүүлэх, Улс, үндэстний тусгаар тогтнолын үнэ цэнийг сурталчлан дэлгэрүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.3.1.Ерөнхий боловсролын сургуулиуд Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орныг батлан хамгаалах, эх орны бүтээн байгуулалтад гавьяат үйлс бүтээсэн баатарлаг өвөг дээдэс, цэрэг дайчид, хөдөлмөрийн алдартан, эрдэмтэн, урлаг, соёлын зүтгэлтнүүдийг алдаршуулах;

7.3.2.Монгол Улсын Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагааг хүүхэд залуучуудад сурталчлан таниулж, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлж, сурталчлах;

7.3.3.Монголын түүх, уламжлалт хууль тогтоомж, монгол ахуй, ёс заншил, эх оронч үзлийг сурталчилсан танхимыг ерөнхий боловсролын сургуулиудад, цэргийн анги, байгууллагад “Соёл амралтын өрөө”-г жил бүр тохижуулах;

7.3.4.Эх оронч үзэл, ёс зүй, ухамсрыг төлөвшүүлэх, батлан хамгаалах үйл ажиллагааг сурталчлан дэлгэрүүлэх зорилготой хүүхэд, залуучууд мэдээлэл олж авах тохиромжтой контентын хэлбэрийг өргөжүүлэх;

7.3.5.“Би эх орны ирээдүй” арга хэмжээг жил бүр уламжлал болгон байгуулж, эх оронч үзлийг олгох цуврал хичээлийг ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад зохион байгуулах;

Шалгуур үзүүлэлт:

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин 2024 он | Зорилтот түвшин | | | |
|------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-------------------------|-----------------|---------|---------|---------|
| | | | | 2025 он | 2026 он | 2027 он | 2028 он |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| <i>Зорилт 1.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.</i> | | | | | | | |
| 1. | Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулах “Эх оронч үзэл, төлөвшил”-тэй холбоотой видео, контентын бичлэгийн уралдаан | Тоо | - | 1 | 1 | 1 | 1 |
| 2. | ХХЕГ-тай хамтран зохион байгуулах ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдыг “Хилийн багана” үзүүлэх үйл ажиллагаа; | Тоо | - | - | - | 1 | 1 |
| 3. | Ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдад бие бялдрын өв тэгш хүмүүжил олгох зорилгоор “Уулын явган аялал”-д хамрагдсан байдал | Тоо | - | 300 | 300 | 250 | 250 |
| 4 | Зэвсэгт хүчний анги байгууллагын “Энхийг сахиулагч” алба хаагчдыг урьж ахлах ангийн сурагчдад хичээлд хамрагдсан байдал | Тоо | 800 | 1000 | 1000 | 1200 | 1200 |

| | | | | | | | |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|-----|-----|-----|---|---|
| 5 | Батлан хамгаалах яамны Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн судлаачидтай хамтран ажилласан эсэх | Тоо | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 6 | Ерөнхий боловсролын сургуулиуд "Зөв төлөвшил хүмүүжил олгоход эцэг эхийн оролцоо"-г уялдуулсан байдал | Тоо | - | 1 | 1 | 1 | 1 |
| Зорилт 2.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэхэд бүх талын оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулна. | | | | | | | |
| 1. | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын эцэг эх, гэр бүлд "Тусгаар тогтнолын үнэ цэнэ ба бидний бахархал" аян зохион байгуулсан байдал | Тоо | - | 1 | 1 | - | - |
| 2. | Ерөнхий боловсролын сургуулиудын дунд "Эх оронч гэр бүл" сэдэвт болзолт уралдаан зохион байгуулсан эсэх | Тоо | - | - | - | 1 | 1 |
| 3. | "Би таны үргэлжлэл" арга хэмжээг зохион байгуулсан эсэх | Тоо | 1 | 1 | 1 | - | - |
| Зорилт 3.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, ёс зүй, ухамсрыг төлөвшүүлэх, улс, үндэстний тусгаар тогтнолын үнэ цэнийг сурталчлан дэлгэрүүлнэ. | | | | | | | |
| 1. | Ерөнхий боловсролын сургуулиудад Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орныг батлан хамгаалах, эх орны бүтээн байгуулалтад гавьяат үйлс бүтээсэн алдартнуудын нэрэмжит танхимыг тохижуулж, мөнхжүүлсэн эсэх | Тоо | 3 | 4 | 4 | - | - |
| 2. | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг Зэвсэгт хүчин, Хилийн ба Дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаатай танилцуулсан байдал | Тоо | 600 | 800 | 800 | - | - |
| 3. | Цэргийн анги, байгууллагын "Соёл амралтын өрөө"-г Монголын түүх, уламжлалт хууль тогтоомж, Монгол ахуй, ёс заншил, эх оронч | Тоо | - | 1 | 1 | - | - |

| | | | | | | | |
|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|------|------|------|---|---|
| | үзлийг сурталчилсан жил бүр тохижуулсан эсэх; | | | | | | |
| 4 | Эх оронч үзэл, ёс зүй, ухамсрыг төлөвшүүлэх, батлан хамгаалах үйл ажиллагааг сурталчлан дэлгэрүүлсэн цуврал контент хийсэн эсэх | Тоо | 2 | 3 | 3 | - | - |
| 5 | “Би эх орны ирээдүй” арга хэмжээг зохион байгуулсан байдал | Тоо | 1200 | 1800 | 1800 | - | - |